



## ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 02 өдөр

Дугаар А/167

Эрдэнэт

### Улсын онцгой комиссын шийдвэрийг хэрэгжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 "а", 29.1.5 "в", 29.1.6 "л", 29.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.2, 32 дугаар зүйлийн 32.1, Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 17.2 дахь заалт, Засгийн газрын 2021 оны 27, 45 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын 2021 оны 01 дүгээр тогтоол, Улсын Онцгой комиссын 2021 оны 09, 10 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн нутаг дэвсгэрт гарсан Коронавируст халдвар (Ковид-19)-ын зарим тохиолдлуудын эх үүсвэр нь тодорхойгүй, цаашид хүн амын дунд халдвар эрчимтэй тархах эрсдэлтэй байгаа тул аймгийн хэмжээнд 2021 оны 04 дүгээр сарын 03-ны өдрөөс 2021 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийг дуусталх хугацаанд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсүгэй. Үүнд:

1.1 Боловсрол, соёл, урлагийн салбарын үйл ажиллагааг цахимд шилжүүлж бусад байгууллагууд албан хаагчдаа хамгийн багаар тооцож боломжит хэмжээгээр биечлэн ажиллуулах, байгууллагынхаа нэн шаардлагагүй үйл ажиллагааг түр зогсоох

1.2 Нийт байгууллага, аж ахуйн нэгжүүд биечлэн ажиллаж байгаа ажиллагсадаа "гэр-ажил-гэр" гэсэн зарчмыг баримтлан ажиллуулах, тухайн байгууллага 14 хоног тутамд халдварын тандалтыг байгууллагынхаа хэмжээнд хийж, халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр онцгой анхаарч ажиллах

1.3 Эрдэнэт хотын хэмжээнд нийтийн тээврийн үйлчилгээг тусгай горимд шилжүүлэх

1.4 Нэг дор 5-аас дээш хүн цуглуулахгүй байх дэглэм журмыг чанд мөрдөх

1.5 Үйлчилгээний байгууллагууд сагсны үйлчилгээг (зай талбайдаа тохирсон тоогоор сагсыг үүдэндээ байрлуулах) нэвтрүүлэх


1.6 Аймгийн Засаг даргын 2021 оны А/140, А/151 дүгээр захирамжуудыг чанд мөрдөх

2.Коронавируст халдвар цаашид хүн амын дунд эрчимтэй тархах эрсдэлтэй байгаа тул иргэн бүр онцгой анхаарч аль болох гэрээсээ гарахгүй байх, олон нийтийн газраар явахгүй байж, амны хаалтыг байнга хэрэглэн халдвар хамгааллын дэглэмийг сахиж байхыг аймгийн нийт иргэддээ уриалсугай.

3.Орхон аймаг, Эрдэнэт хотод орж, гарч, дамжин өнгөрч байгаа тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд тавих хяналтыг эрчимжүүлж, жолооч, зорчигчдоос түргэвчилсэн оношлуураар шинжилгээг төлбөртэй авах асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, албан ёсны хяналтын постоор орж ирээгүй зөрчил гаргасан тээврийн хэрэгслийг журамлаж ажиллахыг Онцгой байдлын газар (Г.Ганбаатар), Цагдаагийн газар (С.Цэрэнсамбуу), Тагнуулын газар (М.Очирбат), Эрүүл мэндийн газар (Д.Сүхээ), Мэргэжлийн хяналтын газар (Б.Жигдэнгомбо), Хүнс, хөдөө аж ахуйн газар (Ж.Бат-Өлзий), Мал эмнэлгийн газар (П.Эрдэнэжаргал), Авто тээврийн төв (Г.Ядмаа), Баян-Өндөр сум (Б.Баасансүрэн), Жаргалант сум (Б.Зоригтбаяр) нарт даалгасугай.

4.Энэхүү захирамжийг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцож ажиллахыг Онцгой байдлын газар (Г.Ганбаатар), Цагдаагийн газар (С.Цэрэнсамбуу), Мэргэжлийн хяналтын газар (Б.Жигдэнгомбо), Авто тээврийн төв (Г.Ядмаа), Баян-Өндөр сум (Б.Баасансүрэн), Жаргалант сум (Б.Зоригтбаяр) нарт үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, арга зүй дэмжлэгээр ханган, ажиллахыг аймгийн Засаг даргын Нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч А.Түвшинжаргал, аймгийн Засаг даргын орлогч М.Түмэнжаргал, Онцгой байдлын газрын дарга, хурандаа Г.Ганбаатар нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  С.БАТЖАРГАЛ